



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМД

2024. 08. 05 № ГНАГ-2024/13 - МТА - НА - 18  
танай -ны № -т

### Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт


Монгол Ардын намын Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шаамар сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (.8.. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Шаамар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН  
ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

ШААМАР СУМ  
2024 ОН



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС  
ДЭВШҮҮЛЖ БҮЙ**

## **МОРИЙН ХӨТӨЛБӨР**

**2024.06.24**

**Шаамар сум**

### **ШААМАР САЙХАН НУТГИЙНХАА ХӨГЖЛИЙГ “ХАМТДАА ШИЙДЬЕ - ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”**

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын хорооноос дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг үндсэн чиглэл болгон Шаамар сумын Монгол Ардын намын хорооноос УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаяа хэрэгжүүлэх, орон нутгийнхаа ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас мөрийн хөтөлбөрт тусгувулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан үзэж, нэгтгэн дүгнэж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Монгол Ардын Намын Хорооноос 2024-2028 онд Шаамар нутгийнхаа хөгжил, дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 1.1. Иргэдийг халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах ажлыг хэвшүүлнэ.
- 1.2. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг чанаржуулна.
- 1.3. Сумынхаа иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх эрүүл, амьдралын дадлыг хэвшүүлэх, гамшиг, ослын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.
- 1.4. Сумын алслагдсан хэсгийн айл өрх, малчдад эрүүл мэндийн явуулын тусlamж үйлчилгээг жил бүр хүргэх ажлыг зохион байгуулна.

- 1.5. Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын өргөтгөл, авто машины парк шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлж, техник хэрэгслээр ханган, ая тухтай орчинд оношлох, эмчлэх боломж бурдүүлнэ.
- 1.6. Нарийн мэргэжлийн эмчээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудад олгох урамшууллын бодлогыг хэрэгжүүлж, тогтвортой суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бурдүүлнэ. МЮА0065 9055436
- 1.7. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургах, мэргэшүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.8. Хүн амын ундны усны ариун цэврийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэж, хариу арга хэмжээг авснаар энгийн уурхайн худгийн усны хүнсний хэрэглээг бууруулна.
- 1.9. Нүхэн жорлонгийн хэрэглээг бууруулах хөтөлбөрийг боловсруулж, сумын ИТХ-аар батлуулан санхүүгийн эх үүсвэрийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар шийдэх ажлыг эхлүүлнэ.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 2.1. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд хамтарч ажиллана.
- 2.2. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насын хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 2.3. Монгол ухаан, Монгол соёл, өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэхэд бага дунд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
- 2.4. Цэцэрлэг, сургуулийн анги танхимыг камержуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бурдүүлнэ.
- 2.5. Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсролын сургалтын чанар, сургууль цэцэрлэгийн үдийн хоолны тэжээллэг чанарт хөндлөнгийн хяналтыг хийж, эцэг эхчүүдэд танилцуулж, үнэлүүлэх ажлыг хэвшүүлнэ.
- 2.6. Тусгай хэрэгцээт хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурх, хөгжих орчин нөхцөлийг бурдүүлж хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 2.7. Сургалтын заах орчинд дэвшилтэд технологийг бурдүүлэх, ухаалаг самбартай болгох, багш нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.8. Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлж, англи хэлийг эзэмших нөхцөл, орчныг бурдүүлэн, англи хэлний багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулна.
- 2.9. Орон нутагт дутагдалтай багшийн мэргэжлээр амжилттай суралцаж, төгсөөд орон нутагтаа ирж ажиллах багш нарт тогтвортой суурьшилтай ажиллах бүх талын дэмжлэг үзүүлнэ.


- 2.9. Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлэх, үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулах, давтан сургах, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.10. Боловсролын байгууллагуудын барилга байгууламжийн их засварыг холбогдох яам, УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсөвт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулснаар боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.
- 2.11. Улсын болон олон улсын чанартай уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон хүүхэд багачууд, сурагчдад дэмжлэг үзүүлж, багш нарын амжилт гаргасан үзүүлэлтээр урамшуулал олгох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.12. Политехникийн коллежийг мэргэжлийн багшаар бүрэн хангах, суралцах мэргэжлийн төрөл, элсэлтийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛ, УРЛАГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 3.1. Соёлын салбарт ажиллагсдын мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлэн, мэргэжлийн ажилтнаар ханган, соёл урлагийн салбарын үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- 3.2. “Соёлч иргэн”, “Соёлч гудамж”, “Соёлч хамт олон” хөтөлбөрийг хэрэгжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагууд сар бүр соёлын ажлыг зохион байгуулдаг тогтмол өдөртэй болж, иргэдийн идэвх санаачилга дээр тулгуурлан хот, суурины соёлыг дэлгэрүүлнэ.
- 3.3. Соёл, урлагийн байгууллагуудын барилгын засвар, тохижилт, хөгжим техник хэрэгслийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэдэд ая тухтай орчинд боломжийг дээшлүүлнэ.
- 3.4. Сумын Номын санд “Цахим ном”-ыг нэмж, хүүхэд залуусыг ном унших, ном сонсож мэдлэгтээ хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлнэ.
- 3.5. Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.6. Залуусын санал санаачилгыг дэмжиж, хүүхэд, залуучуудын авьяас сонирхлыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулсан дугуйлан, клуб байгуулах санал санаачилгыг дэмжинэ.
- 3.7. Сумын түүхэн дурсгалт хөшөө дурсгалын газрууд болон байгалийн үзэсгэлэнт газруудаараа аялал зугаалгын газрыг эмх цэгцтэй, харуул хамгаалалттайгаар нийтэд буюу жуулчдад үзүүлэх, таниulan сурталчлах боломжийг нэмэгдүүлснээр орон нутгийнхаа эдийн засагт зохин хувь нэмрийг оруулна.
- 3.8. Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг соёл, урлагийн чиглэлээр улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх, урамшуулах асуудлыг хувийн хэвшилтэй хамтран шийдвэрлэнэ.

### **ДӨРӨВ. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 4.1. Эрүүл зан үйлийг хэвшүүлэх, дасгал хөдөлгөөнийг дадал болгож, нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн хүрээг нэмэгдүүлж, спортын олон төрөлт арга хэмжээг төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ.

- 4.2. Төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлтийн тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 4.3. Сумын хэмжээнд үндэсний сур, шагайн харвааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, үндэсний спортыг хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллана.
- 4.4. Дугуйн болон явган аяллыг дэмжиж, сумын төвөөр дайран өнгөрөх асфальтан замын дагуу явган хүний болон дугуйн зам байгуулах ажлыг улсын 4317143998 хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ. 
- 4.5. Сумын аварга шалгаруулах спортын олон төрлийн тэмцээн уралдааныг жил бүр зохион байгуулж, аймаг, бусийн тэмцээн уралдаанд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх ажлыг хувийн хэвшлийг түшиглэн зохион байгуулна.
- 4.6. Биеийн тамир, спортын байгууллагуудын барилгын засвар, тохижилт, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг дээшлүүлнэ.

#### **ТАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 5.1. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хөдөлмөр зуучлалын үйлчилгээг чанаржуулж, хөдөлмөрийн бирж ажиллуулан, ажилтай өрх хөтөлбөрийг хэрэгжүүлж 40 дээш шинэ ажлын байр бий болгоно.
- 5.2. Ажилгүй иргэдийг мэргэжил олгох болон давтан сургалтад хамруулан мэргэжлийн зөрүүгээс ажилгүйдэл үүсэх шалтгааныг бууруулж өрх бүр ажилтай орлоготой болох боломжийг нэмэгдуулнэ.
- 5.3. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж, жил бүр 20-оос доошгүй идэвхтэй ажлын байр хайгчдыг түр ажлын байраар хангана.

#### **ЗУРГАА. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 6.1. Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.2. Гэр булийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.3. Ахмад настны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэгч сум болно.
- 6.4. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх боломжийг бүрдүүлнэ.
- 6.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 6.6. Зорилтот бүлгийнхэнд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана

- 6.7. Жендерийн тэгш байдлыг хангах бодлогыг бүх шатны байгууллагад хэрэгжүүлнэ.
- 6.8. Орхийн аж ахуй эрхлэгч иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулан өрхийн амьжиргааны тувшиг сайжруулна.
- 6.9. Сайн дурын даатгалд хамрагсдын тоог нэмэгдүүлж, албан бус салбарт ажил хөдөлмөр эрхлэгчид, малчдын нийгмийн даатгалыг хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

## ДОЛОО. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

43998  
МЮА0065 9055436

- 7.1. Тариалангийн үйлдвэрлэлд тэг болон цомхотгосон, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, байгальд зэлтэй бордооны хэрэглээг төлөвшүүлж, хөрсний Үржил шимийг хамгаалж, сайжруулна.
- 7.2. Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, Үржил шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.
- 7.3. “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хэрэгжүүлж, тариалах талбайн хэмжээг, нэр төрлийг олшруулан боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 7.4. Төмс хүнсний ногоо тариалагч өрхийн аж ахуй эрхлэгч иргэдийг бага оврын техникээр хангаж, ХАА-д ашиглагдаж байгаа техник тоног төхөөрөмжийг шинэчлэх санхүүжилт, зээлд хамрагдах боломжийг бүрдүүлж өгнө.
- 7.5. Зоорины аж ахуйг хөгжүүлж, тариаланч ногоочдын хөдөлмөрийг үр шимийг нэмэгдүүлэх, төмс хүнсний ногоог үнэгүйдүүлдэг нөхцөл байдлыг бууруулна.
- 7.6. Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээнд тогтвортой нийлүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг сайжруулна.
- 7.7. Хүнсний ногоо тариаланчдын бүтээгдэхүүнийг борлуулах цэгийг Дархан хотод бий болгох ажлыг холбогдох удирдлагуудад уламжилж шийдвэрлэнэ.
- 7.8. “Монгол мал” хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг сум орон нутгийнхаа онцлогт тохируулан хэрэгжүүлнэ.
- 7.9. Мал сургийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг тогтмолжуулж, халдварт өвчинеөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулна.
- 7.10. Дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахиа шувуу, зөгийн аж ахуйг шат дараатайгаар хөгжүүлнэ.
- 7.11. Суманд мал угаах ванныг шинээр байгуулах, хашаажуулах ажлыг малын хөлийн татвараар шийдвэрлэнэ.
- 7.12. Хоршоололд суурилсан хамтын хариуцлагын 3-5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл, хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 7.13. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогод дэмжлэг үзүүлнэ.

- 7.14 Бэлчээрийг хортон мэрэгчдээс хамгаалах, бордох, усжуулах, олон наст ургамал тариалах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.
- 7.15 Иргэдийн хадлангийн газрыг жил бүр малын тоо толгойд нийцүүлэн хуваарилах ажлыг зохион байгуулж, сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлж ажиллана.

### **НАЙМ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 8.1. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомстол, доройтлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 8.2. Бэлчээрийн доройтолд орсон газар нутагт үлийн цагаан оготны тархац судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх ажлыг хийнэ.
- 8.3. Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдал, ойн нехөрлөлүүдийн үйл ажиллагааг жил бүр бодитоор үнэлж хариуцлагажуулна.
- 8.4. Голын эх, ус намаг бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, барилгажих, эзэмших, бохирдуулахаас сэргийлэн шингээх чадварыг хэвээр нь хадгалах замаар үерийн эрсдэлийг бууруулна.
- 8.5. Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### **ЕС. ДЭД БУТЦИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 9.1. Сумын төвийн зарим хэсгийг гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, замын тэмдэг тэмдэглэгээ, хаягжилтыг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 9.2. Цахилгааны хүчдэл уналттай хуучирч муудсан 04 квт-ын шугамыг үе шаттайгаар шинэчлэх ажлын саналыг мэргэжлийн байгууллагад уламжилж шийдвэрлэнэ.
- 9.3. 5-н толгойн хэсэгт байрлах гүний худгийг ухаалаг тоолууртай болгож хүн амыг ундны цэвэр усаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ
- 9.4. Нийтийн ахуйн үйлчилгээг түшиглэн “Шаамар-Тохижилт” ОНӨТҮГ-ыг байгуулж, сумын өнгө үзэмжийг сайжруулж, хоггүй сүм болгох аяныг өрнүүлнэ.
- 9.5. Сумын төвөөс алслагдсан хөдөөгийн хэсгийг сайжруулсан замаар холбох, тосгоны 4-н замаас төмөр замын гаралт хүртэлх замыг засаж нөхөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 9.6. Сумын төвд шатахуун түгээх газрыг байгуулах санал санаачилга гаргасан иргэн, аж ахуй нэгжийг дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 9.7. Дулаанхаан тосгоны халуун усны барилгыг ашиглалтад оруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэнэ.

- 9.8. Сумын төвийн гудамж талбайд хогийн бункер, дахин ашиглах боломжтой хог хаягдлын савыг нэмж байрлуулан, хогийн нэгдсэн цэгийг хашаажуулж, замыг засаж сайжруулна.
- 9.9. Дулаанхаан тосгонд ковш трактортой болгох асуудлыг аймгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.
- 9.10 Сумын төвд түлээ нүүрсний нэгдсэн цэг байгуулж, ард иргэдийг зүсвэрийн мод мөдөн материал, хямд өртөгтэй шаталт сайтай нүүрсээр хангах ажлыг хэрэгжүүлнэ.
- 9.11 ТИКА төслийн хүрээнд сумын ард иргэдэд барьж өгсөн зөгийн аж ахуйн сэмжний үйлдвэрийг ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 9.12 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлнэ.
- 9.13 Монгол улсын иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 9.14 Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг олон нийтийн нээлттэй санал асуулга явуулан, дээд шатны байгууллагаар хэлэлцүүлж сумын ИТХ-д өргөн барих ажлыг хуулийн дагуу гүйцэтгэн, төсөл, хөтөлбөр, төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, зээлийг олон нийтэд ил тод нээлттэй хэлэлцүүлнэ.


#### **АРАВ. НУТГИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 10.1. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, хөтөч үйлчилгээг нэвтрүүлэн, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлнэ.
- 10.2. Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал, урамшуулал, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 10.3. Төрийн албан хаагчийг гадаад, дотоодын хэрэгцээт сургалтад хамруулах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулна.
- 10.4. Төрийн байгууллагын ажил, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахимаар илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 10.5. Төрийн албандаа таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг гадаадад хэлний бэлтгэл болон ахисан түвшний сургалтад хамруулах бодлогын хэрэгжүүлж ажиллана.

#### **АРВАН НЭГ. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 11.1. Хууль, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулан, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулна.
- 11.2. Хүнийг эрхийг хангахад нутгийн захиргаа, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 11.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, сумын тодорхой цэгүүдэд камер байршуулна.

- 11.4. Хүүхдийг ёс суртахуун, зан заншлын буруу зуршилд автхааас урьдчилан сэргийлэх, болзошгүй осол, гэмт үйлдлээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшүүлнэ.
- 11.5. Иргэд болон авлигатай тэмцэх төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, авлигагүй орчин бүрдүүлж ажиллана.



**ИЛҮҮ СЭТГЭЛЭЭР ЗҮТГЭЖ, ИЛҮҮ ХУРДАН ХӨГЖҮҮЛЬЕ !**